

ДОЛЛАРЖИЛТ

Монгол банкны судалгааны хэлтсийн эдийн засагч Б.Лхагважав

I. ОРШИЛ

Ямар нэгэн орны иргэд үндэсний мөнгөн тэмдэгтгүйгээ зэрэг буюу түүний оронд өөр орны валютыг өргөн ашиглаж байгаа үзэгдлийг долларжилт гэдэг байна. Долларжилт гэдэг нь АНУ-ын доллар төдийгүй бусад орны хатуу валютыг хамарсан илүү өргөн ойлголт юм. Энэхүү судалгааны зорилго нь долларжилтын ямар төрлүүд байдаг, түүнийг хэрхэн яаж хэмждэг, Монголд долларжилт ямар шатандаа байгааг тодорхойлоход оршино.

II. ОНОЛЫН ХЭСЭГ

Долларжилт: бий болох нөхцөл

Долларжилт гэдэг үзэгдэл үндсэн 2 нөхцөлд ажиглагддаг байна. Үүнд:

- 1) Үндэсний мөнгөн тэмдэгтийн тогтвортой байдал алдагдахад -- долларжилт нь үндэсний мөнгөн тэмдэгтийн тогтвортой байдлаас ихээхэн шалтгаалдаг ажээ. Олон Улсын Валютын Сан 1971 онд үндэсний мөнгөн тэмдэгтийн тогтвортой байдлыг дараахь 3 шалгуураар тодорхойлохыг санал болгожээ. Үүнд:
 - жилийн инфляци 20 хувиас хэтрэхгүй;
 - доллартай харьцуулсан номиналь ханшны жилийн сулралт 25 хувиас хэтрэхгүй;
 - гадаад валютыг худалдаж авахад ямар нэгэн хориг саад тавихгүй байх;Энэ шалгуурууд өдгөө хүртэл хүчинтэй байгаа ба хөгжиж буй Олон Улсын Валютын Сангийн гишүүн орнуудаас энэ шалгуурыг зөвхөн Панама улс л тогтвортой хангасаар байна.
- 2) Тухайн орны засгийн газар өөр орны мөнгөн тэмдэгтийг цорын ганц хууль ёсны төлбөр тооцооны хэрэгсэл мөн гэж хүлээн зөвшөөрч буй тохиолдолд – Сүүлийн үед долларжилтын асуудал бүрэн буюу албан ёсны долларжилттай холбоотойгоор их яригдах болжээ. Тухайлбал 1999 оны эцсээр Аргентины засгийн газар долларжих талаар АНУ-тай албан ёсоор тохиролцсон байхад Эквадор улс 2000 оны 1 дүгээр сарын 9-нд бүрэн долларжих тухайгаа албан ёсоор зарлаж байжээ.

Долларжилт: үндсэн төрлүүд болон хэрхэн хэмжих тухай

Долларжилтын дараахь 2 төрлийг авч үздэг байна. Үүнд:

- 1) *Активын долларжилт (asset dollarization)* – мөнгөний 3 функцийг (тооцооны, төлбөрийн, баялаг хуримтлуулах хэрэгслийн) нэгэн зэрэг буюу тусад нь биелүүлэхэд гадаад валютыг ашиглаж байгаа явдлыг ойлгоно. Долларжилтыг үндэсний мөнгөн тэмдэгтийг орлуулах үйл явц гэж үзвэл түүнийг хэмжих хамгийн сайн арга нь эргэлтэнд байгаа гадаад валют, банкны системд байгаа гадаад валютын хадгаламжийн хэмжээ болон гадаадад байршуулсан гадаад валютын нөөц

зэрэг болно. Гэвч нэг талаас гадаад банкуудад байгаа гадаад валютын хэмжээг тодорхойлох нэн түвэгтэй, нөгөө талаас эргэлтэнд байгаа гадаад валютын хэмжээг (ялангуяа бэлэн валют) тодорхойлох нь түүнээс ч илүү хүнд байдаг байна. Ийм байдлаас үүдээд долларжилтыг илүү явцуу хүрээнд буюу гадаадад байршуулсан болон дотоодод эргэлтэнд явж байгаа валютыг оруулалгүй тооцдог байна.

- 2) *Өрийн долларжилт (liability dollarization)* – тухайн орны банкны систем эсвэл засгийн газар нь харьцангуй их хэмжээний гадаад валютын өрийн бичигтэй байж болно. Улс орон актив талдаа маш сул долларжилттай хэрнээ банкны системийн олгосон зээлийн дийлэнхийг гадаад валютаар олгосон байж болдог. Банкны системээс олгосон нийт зээлд валютын зээлийн эзлэх хувийг тодорхойлсноор өрийн долларжилтыг хэмжинэ.

Долларжилт: хууль эрх зүйн асуудлууд.

Хууль эрх зүйн хувьд албан ёсоор зөвшөөрөгдсөн эсэхээс шалтгаалан долларжилтыг дараахь 3 төрөлд ангилдаг байна.

- *албан ёсны бус долларжилт (unofficial dollarization)* – үндэсний мөнгөн тэмдэгтийн ханш сулралтаас иргэд өөрсдийгөө хамгаалах үүднээс арилжааны банкинд гадаад валют хадгалж байгаа явдал юм (АНУ-ын долларын бүсэд – Төв болон Латин Америк, Карибын ихэнх улс орнууд, тухайлбал Аргентин, Боливи, Мексик, Перу, ТУХН-ын ихэнх гишүүн улс, Мозамбик, Румын, Турк, Вьетнам). Энэ бүлэгт Монгол улс багтдаг байна.
- *хагас албан ёсны долларжилт (semiofficial dollarization)* – хэдий тухайн гадаад валют хууль ёсны төлбөр, тооцооны хэрэгсэл мөн боловч цалин хөлс, татвар, өдөр тутмын зардалд хоёрдогч үүрэг гүйцэтгэдэг. Ийм улс оронд банкны хагаламжид гадаад валют давамгайлах нь бий (АНУ-ын долларын бүсэд – Багамын арал, Камбож, Гаити, Либер).
- *албан ёсны долларжилт (official or full dollarization)* – засгийн газар нь тухайн гадаад валютыг ноёлох буюу цорын ганц хууль ёсны мөнгөн тэмдэгт гэж хүлээн зөвшөөрч байгаа явдал юм. (Хавсралт 1-ийг үзнэ үү)

III. ӨГӨГДӨЛ БОЛОН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Төгрөгийн тогтвортой байдлын тухай

Монгол улсад ажиглагдаж буй долларжих явц нь үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгийн тогтвортой байдал алдагдсантай шууд холбоотой. Харин 1997 оноос хойш ам.долларын ханш болон инфляцийн түвшин харьцангуй тогтворжих хандлагатай байна.

Ам.долларын ханш ба инфляцийн түвшин 1990-2000 онд

Он	Ам.долларын ханш, оны эцэст		Инфляци
	төг	өсөлт	
1990	5.4		
1991	40.0	640.7%	52.7%
1992	150.0	275.0%	325.5%
1993	396.5	164.3%	183.0%
1994	414.1	4.4%	66.3%
1995	473.6	14.4%	53.1%
1996	693.5	46.4%	44.6%
1997	813.2	17.3%	20.5%
1998	902.0	10.9%	6.0%
1999	1072.4	18.9%	10.0%
2000	1097.0	2.3%	8.1%

Монгол дахь активын долларжилтын явц

Монгол улсын активын долларжилтын явцыг оны эцсээр болон 12 сарын арифметик дунджаар харуулбал дараахь байдалтай байна.

Активын долларжилт

Он	М2-т гадаад валютын* эзлэх хувь	
	Оны эцэст	12 сарын арифметик дундаж
1988	3.5%	
1989	2.0%	
1990	2.8%	
1991	6.1%	
1992	7.5%	6.3%
1993	33.0%	30.0%
1994	19.5%	25.5%
1995	20.5%	19.6%
1996	22.5%	19.9%
1997	29.0%	25.2%
1998	23.8%	25.4%
1999	27.4%	27.7%
2000	26.7%	26.0%

*Жич: *Гадаад валютын хадгаламжинд валютын хугацаатай болон хугацаагүй хадгаламж болон валютын харилцах орсон болно.*

Активын долларжилт хэр зэрэг идэвхтэй явагдаж байгаагаас үүдэн тухайн эдийн засгийг 3 ангилж үздэг байна:

1. Бага долларжилттай эдийн засаг (20 хувиас доогуур): Чили, Сальвадор, Мексик. Зарим хэвлэлд 30 хувиас бага гэсэн шалгуур ч хэрэглэх нь бий.
2. Дунд зэргийн долларжилттай эдийн засаг (20-70 хувь): Аргентина, Коста Рика, Гондурас, Никарагуа. Энэ бүлэгт багтах Монгол улсын долларжилт 1993 оноос хойш 19.5-33.0 хувийн хооронд хэлбэлзэж байсан нь доорх графикаас харагдаж байна.



3. Өндөр долларжилттай эдийн засаг (70 хувиас дээш): Боливи (82.3%), Уругвай (76.1%)

Монгол дахь өрийн долларжилтийн явц

Монгол улсын өрийн долларжилтыг оны эцсээр болон 12 сарын арифметик дунджаар харуулъя:

Он	Нийт зээлд валютын зээлийн эзлэх хувь	
	Оны эцэст	12 сарын арифметик дундаж
1992	2.2%	
1993	15.2%	11.6%
1994	14.9%	16.7%
1995	14.2%	14.9%
1996	16.4%	15.0%
1997	32.6%	29.4%
1998	46.7%	46.9%
1999	39.2%	46.8%

2000	41.4%	42.6%
------	-------	-------

Нийт зээлд валютын зээлийн эзлэх хувь 1997 он хүртэл 20 хувиас хэтэрдэггүй байсан бол 1997 онд 32.6%, 1998 онд 46.7%, 1999 онд 39.2%, 2000 онд 41.4% болтлоо өсчээ. 1997 оны 5 дугаар сард гаалийн худалдааны алдагдал 1998 онд 9.4 дахин нэмэгдэж 158.1 сая ам.долларт хүрчээ. Гадаад худалдааны алдагдал 1999 онд 154.5 сая, 2000 онд 141.9 сая байв.

Гадаад худалдааны эргэлт, сая ам.доллар

Он	Нийт эргэлт	Экспорт	Импорт	Сальдо
1990	1584.7	660.7	924.0	-263.3
1991	708.9	348.0	360.9	-12.9
1992	806.7	388.4	418.3	-29.9
1993	761.6	382.6	379.0	3.6
1994	614.5	356.1	258.4	97.7
1995	888.6	473.3	415.3	58.0
1996	875.2	424.3	450.9	-26.6
1997	919.8	451.5	468.3	-16.8
1998	848.4	345.2	503.3	-158.1
1999	871.1	358.3	512.8	-154.5
2000	1006.5	432.3	574.2	-141.9

1997 оноос хойш валютаар олгосон зээлийн өслөтийг импортын санхүүжилтийн өсөлтөөр тайлбарлаж болох талтай. Өрийн долларжилт 1997 оноос огцом өсч байгаа нь дараахь графикаас тод харагдаж байна.



Албан бус долларжилт: хөгжлийн шат

Дээр Монгол улс албан ёсны бус долларжилттай улсын тоонд ордог гэж цухас дурьдсан билээ. Энэхүү албан ёсны бус долларжих процесс 3 шаттай байдаг байна. Үүнд:

1. “*активын орлуулалт*”-ын шат (*asset substitution*): үнийн өсөлтөөс хамгаалж баялгынхаа үнэ цэнийг алдахгүйн тулд хүмүүс гадаад валютын хадгаламжтай болохыг эрмэлзэнэ. Энэ үед гадаад валют мөнгөний баялаг хуримтлуулах үүрэг гүйцэтгэхээс биш төлбөр тооцооны хэрэгсэл болдоггүй. Монгол улсад долларжилт ба жилийн инфляци 1988-2000 онд дараахь байдалтай байсан байна.

Активын долларжилт ба инфляци

Он	Долларжилтын түвшин	Жилийн инфляци
1988	3.5%	
1989	2.0%	
1990	2.8%	
1991	6.1%	52.7%
1992	7.5%	325.5%
1993	33.0%	183.0%
1994	19.5%	66.3%
1995	20.5%	53.1%
1996	22.5%	44.6%
1997	29.0%	20.5%
1998	23.8%	6.0%
1999	27.4%	10.0%
2000	26.7%	8.1%

Хүснэгтээс харахад 1992 оны 325.5 хувьтай өндөр инфляци 1993 онд гадаад валютын хадгаламжийн огцом өсөлтийг бий болгосон нь харагдаж байна. Долларжилт 1992 онд 7.5 хувьтай байсан бол 1993 онд даруй 4.4 дахин нэмэгдэж 33.0 хувьтай болжээ. Сүүлийн жилүүдийн динамикийг харахад инфляци аажмаар саарч байгаа бөгөөд активын долларжилтын түвшин тогтворжих хандлагатай байна.

2. “мөнгөн тэмдэгтийн орлуулалт”-ын шат (*currency substitution*): хүмүүс валютыг төлбөрийн болон баялаг хуримтлуулах хэрэслийн хувьд дотоодын банкны системд (зөвшөөрөгдсөн тохиолдолд), улмаар гар дээр ихээхэн хэмжээгээр байлгана. Цалин хөлс, татвар, өдөр тутмын төлбөр тооцоо зэрэг нь үндэсний мөнгөөр хийгдэж байгаа ч томоохон зүйлийн, тухайлбал автомашин, байр байшин зэргийн тооцоо нь гадаад валютаар хийгдэх нь олонтаа. Монгол улсын хувьд гэвэл гэр ахуйн электрон бараа, компьютер, түүний сэлбэг хэрэгсэл, мебель тавилга, автомашин, орон сууц зэрэг барааг доллараар үнэлж зарах нь хэвийн үзэгдэл болсон төдийгүй үнийн хэлбэлзэл ихтэй үед барааны шошгон дээр долларын үнэлгээг тавьдаг болсон байна.
3. 3 дугаар шатанд валютын ханшны өөрчлөлттэй бараа таваарын үнэ шууд уялдана. 1991-1999 онд ханш ба инфляци ямар байсныг сонирхоё:


Ханш ба инфляцийн өөрчлөлт

Он	Төгрөгийн сулралт	Жилийн инфляци
1991	640.7%	52.7%
1992	275.0%	325.5%
1993	164.3%	183.0%
1994	4.4%	66.3%
1995	14.4%	53.1%
1996	46.4%	44.6%
1997	17.3%	20.5%
1998	10.9%	6.0%
1999	18.9%	10.0%
2000	2.3%	8.1%

Монгол улс хүнсний болон хүнсний бус хэрэглээний бараа таваарын нэлээд хэсгийг импортоор авдаг орон билээ. Өөрөөр хэлбэл ханшны өөрчлөлт үнийн түвшинд шууд тусгалаа олж авдаг байна. 1992-2000 оны төгрөг, ам.долларын ханшны өөрчлөлт болон жилийн инфляцийн хоорондох корреляц хамаарлыг тооцож үзэхэд 0.97 буюу маш өндөр хамааралтай гэж гарахаар байна.

IV. ДҮГНЭЛТ

Активын долларжилт 2000 оны байдлаар 26.7 хувь байгаа нь Монгол улс дунд зэрэг долларжсан орнуудын тоонд орж байгааг харуулж байна. Активын болон өрийн долларжих процесс сүүлийн жилүүдэд харьцангуй тогтворжих хандлага ажиглагдаж байна.



Бусад улс оронтой ялгаагүй албан ёсны бус долларжих явц нь Монгол улсын хувьд өөрийн давуу болон сул талтай юм. Албан ёсны бус долларжих процесс нь инфляцийг зохистой хэмжээнд барих, улс орны дотоодын зах зээлийг олон улсын зах зээлд

интеграцчлах, улс орны төлбөрийн чадварыг нэмэгдүүлэх зэрэг давуу талтай юм. Нөгөө талаас санхүүгийн болон валютын зах зээлийн хямралын эрсдэл нэмэгдэх, seigniorage-орлогоо АНУ-ын засгийн газарт алдах, мөнгөний хараат бус байдлаа алдах зэрэг сул татай юм.

Хавсралт1. 2000 оны 1 дүгээр сарын байдлаар албан ёсоор долларжсан улс орнууд

Улс	Хүн ам	ДНБ, тэрбум \$	Улс төрийн статус	Хэрэглэж буй валют	Хэдэн оноос хойш
Андорра	73000	1.2	Тусгаар	Францийн франк, Испаний пасат, өөрийн динар	1278
Кокос арал	600	0.0	Австралийн гадаад бүс нутаг	Австрали доллар	1955
Кук арал	18500	0.1	Шинэ Зеландын өөртөө засах бүс нутаг	Шинэ Зеландын доллар	1955
Хойд Кипр	180000	1.4	Бараг тусгаар	Туркийн лир	1974
Зүүн Тимор	857000	0.2	Тусгаар	АНУ-ын доллар	2000
Гренланд	56000	0.9	Данийн өөртөө засах бүс нутаг	Данийн крон	1800 оноос өмнө
Гуам	160000	3.0	АНУ-ын бүс нутаг	АНУ-ын доллар	1898
Кирибати	82000	0.1	Тусгаар	Австрали доллар	1943
Лихтенштейн	31000	0.7	Тусгаар	Швейцар франк	1921
Маршаллын арал	61000	0.1	Тусгаар	АНУ-ын доллар	1944
Микронез	120000	0.2	Тусгаар	АНУ-ын доллар	1944
Монако	32000	0.8	Тусгаар	Франц франк/евро	1865
Науру	10000	0.1	Тусгаар	Австрали доллар	1914
Ниу	1700	0.0	Шинэ Зеландын өөртөө засах бүс нутаг	Шинэ Зеландын доллар	1901
Норфолк арал	1900	0.0	Австралийн гадаад бүс нутаг	Австрали доллар	1990 оноос өмнө
Хойд Марианы арал	48000	0.5	АНУ-ын хамтын нийгэмлэг	АНУ-ын доллар	1944

Палау	17000	0.2	Тусгаар	АНУ-ын доллар	1944
Панам	2.7 сая	8.7	Тусгаар	АНУ-ын доллар	1904
Питкейрн арал	42	0.0	Их Британий хараат	Шинэ Зеландын доллар, АНУ-ын доллар	1800
Пуэрто Рико	3.8 сая	33.0	АНУ-ын хамтын нийгэмлэг	АНУ-ын доллар	1899
Сэйнт Хелен	5600	0.0	Их Британий колони	Английн фунт	1834
Америкийн Самао	60000	0.2	АНУ-ын бүс нутаг	АНУ-ын доллар	1899
Сан Марино	26000	0.1	Тусгаар	Итали лир/евро, өөрийн мөнгөн тэмдэгт	1897
Токелау	1500	0.0	Шинэ Зеландын бүс нутаг	Шинэ Зеландын доллар	1926
Туркс ба Кайко арал	14000	0.1	Их Британий колони	АНУ-ын доллар	1973
Тувалу	11000	0.0	Тусгаар	Австрали доллар, өөрийн мөнгөн тэмдэгт	1892
Ватикан хот	1000	0.0	Тусгаар	Итали лир/евро, өөрийн мөнгөн тэмдэгт	1929
Их Британы Виржиний арал	18000	0.1	Их Британий хараат	АНУ-ын доллар	1973
АНУ-ын Виржиний арал	97000	1.2	АНУ-ын бүс нутаг	АНУ-ын доллар	1934
АНУ	268 сая	8100.0	Тусгаар	АНУ-ын доллар	1700

Эх сурвалж: CIA 1998; The Statesman's Year-Book; IMF 1998; World Bank 1999

Ашигласан материал

1. Basics of Dollarization, July 1999 (US Senate Joint economic Committee)
2. On the Definition of Dollarization (The World Bank)
3. Currency Substitution and Dollarization, November 2000 (IMF)
4. Monetary Policy and Dollarized Economics, 1999 (IMF)